ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/04/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Шинжээч Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....9
3.4.1 Мөнгөн хөрөнгө 11
3.5.2 Авлага 11
3.5.4 Бараа материал.....11
3.5.6 Үндсэн хөрөнгө.....12
3.5.7 Өр төлбөр.....13
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо 13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....16
4.1 Ерөнхий зүйл 16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 17
4.5.1 Завсрын аудитын талаар 17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....18
5.3 Зөвлөмж.....18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 01/234
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.МӨНГӨНХАЗААР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна. Төв аймгийн Батсүмбэр сум нь 2023 оныг Түүхт ой бүтээн байгуулалтыг дэмжих урианы жил болгон зарлаж, сумын 100 жилийн ой угтсан бүтээлч ажлын төлөвлөгөөг 4 бүлэг, 76 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр төлөвлөн 47,2 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Тайлант онд байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 9,900.0 мянган төгрөгөөр ногоон байгууламжийн хашаа, Сөгнөгөрийн постны барилгыг 8,000.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн ба ногоон байгууламжийг нэмэгдүүлж мод, бутыг үрээр болон мөчрийн тайрдас, тарьц суулгацаар тарьсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

01902050

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,768,762.4	2,420,257.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,325,326.0	1,512,698.7
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	253,231.7	685,944.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	181,204.7	221,613.4
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	9,000.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,120,718.8	2,485,406.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,120,718.8	2,485,406.0
39200	Биет хөрөнгө		1,468,322.8	1,821,394.6
39300	Биет бус хөрөнгө	13	652,396.1	664,011.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		3,889,481.2	4,905,663.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		3,312.2	44,790.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	3,312.2	44,790.8
41300	Өглөг	17а, 17б	3,312.2	44,790.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,886,169.0	4,860,872.1
51	Засгийн газрын хувь оролцоо		3,886,169.0	4,860,872.1
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,112,351.8	1,112,351.8
51200	Хуримтлагдсан үр дүн		2,546,909.7	3,521,612.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		226,907.4	226,907.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		3,889,481.2	4,905,663.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		4,902,329.5	3,422,952.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,271,169.4	1,309,206.9
110	Орлогын албан татвар		604,274.8	925,805.9
1100	Хувь хүний орлогын албан татвар		638,079.8	965,805.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-33,805.1	-40,000.0
113	Хөрөнгийн албан татвар		130,043.3	107,551.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		536,851.3	275,849.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,110,850.5	639,073.5
120	Нийтлэг татварын бус орлого		1,110,850.5	629,413.5
122	Тусламжийн орлого		0.0	9,660.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,520,309.5	1,474,672.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,353,804.3	2,441,509.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,994,494.9	2,062,975.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,526,382.5	1,992,284.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		424,773.7	681,916.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		54,194.5	83,822.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		564,730.1	54,922.6
2104	Хангамж, бараа материалын зардал		72,114.0	65,759.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		15,286.6	18,732.8
2107	Томилолт, зочны зардал		5,559.1	7,138.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,		69,299.3	9,335.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		320,425.2	1,070,656.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,468,112.5	70,691.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		359,309.4	378,533.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,548,525.2	981,443.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		6,923,175.3	5,608.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-5,374,650.1	975,835.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон / мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)**	4,175,411.2	3,298,989.8
11	**ТАТВАРЫН ОРЛОГО**	1,271,169.4	1,309,206.9
110	**Орлогын албан татвар**	604,274.8	925,805.9
1100	**Хувь хүний орлогын албан татвар**	638,079.8	965,805.9
1101	**Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт**	-33,805.1	-40,000.0
113	**Хөрөнгийн албан татвар**	130,043.3	107,551.0
118	**Бусад татвар, төлбөр, хураамж**	536,851.3	275,849.9
1180	**Бусад нийтлэг төлбөр, хураамж**	38,719.0	35,173.6
1181	**Газрын төлбөр**	19,856.9	148,014.7
1182	**Байгалийн нөөц ашигласны төлбөр**	478,275.4	92,661.6
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	383,932.2	509,366.2
120	**Нийтлэг татварын бус орлого**	383,932.2	499,706.2
122	**Тусламжийн орлого**	0.0	9,660.0
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	2,520,309.5	1,480,416.8
II	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	3,026,823.8	2,070,295.5
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	3,026,823.8	2,070,295.5
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	1,535,898.5	1,999,604.3
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	423,501.0	681,659.5
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	54,498.3	83,976.6
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	565,239.8	107,555.4
2104	**Хангамж, бараа материалын зардал**	61,931.6	67,544.0
2105	**Норматив зардал**	185,171.4	205,733.3
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	17,251.2	5,991.6
2107	**Томилолт, зочны зардал**	4,464.9	7,105.5
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,**	70,493.4	8,271.6
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	153,347.0	831,766.9
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	1,490,925.3	70,691.2
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)**	1,148,587.3	1,228,694.3
V	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)**	314,384.0	915,803.6
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	314,384.0	915,803.6
2200	**Дотоод эх үүсвэрээр**	314,384.0	915,803.6
VI	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)**	-314,384.0	-915,803.6
VII	**САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН**	-40,100.0	-125,518.0
23	**ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ**	40,100.0	125,518.0
VIII	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)**	794,103.3	187,372.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	531,222.6	1,325,326.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,325,326.0	1,512,698.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	**2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	9,441,451.9	9,441,451.9
10	**2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	3,886,169.0	3,886,169.0
3	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	9,260,819.1	9,260,819.1
2	**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт**	-180,632.9	-180,632.9
9	**Тайлант үеийн үр дүн**	-5,374,650.1	-5,374,650.1
11	**2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл**	3,886,169.0	3,886,169.0
13	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	3,885,036.9	3,885,036.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,132.0	-1,132.0
19	Тайлант үеийн үр дүн	975,835.2	975,835.2
20	**2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл**	4,860,872.1	4,860,872.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**3,305,648.1**	**2,631,995.9**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**1,868,108.7**	**1,623,314.2**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**1,803,316.9**	**1,558,725.9**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**636,853.5**	**636,087.2**
210101	Үндсэн цалин	545,713.5	460,455.6
210102	Нэмэгдэл	79,351.7	116,347.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,360.0
210104	Урамшуулал	11,788.3	51,930.7
210105	Гэрээт ажлын хөлс	-	4,993.9
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**79,606.9**	**79,606.9**
210201	Тэтгэврийн даатгал	54,132.5	54,132.5
210202	Тэтгэмжийн даатгал	6,368.6	6,368.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,094.8	5,094.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,273.8	1,273.8
210205	Эрүүл мэндийн даатгал	12,737.2	12,737.2
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**668,957.3**	**652,081.2**
210301	Гэрэл, цахилгаан	73,332.6	67,133.4
210302	Түлш, халаалт	576,075.2	569,088.5
210303	Цэвэр, бохир ус	19,549.5	15,859.4
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**68,238.0**	**66,981.0**
210401	Бичиг хэрэг	2,922.8	2,880.5
210402	Тээвэр, шатахуун	21,935.2	21,977.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,380.0	2,702.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	40,000.0	39,420.6
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**11,700.0**	**10,451.9**
210604	Урсгал засвар	11,700.0	10,451.9
2107	**Томилолт, зочны зардал**	**7,173.8**	**7,105.5**
210702	Дотоод албан томилолт	7,173.8	7,105.5
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний**	**13,751.5**	**17,720.4**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	12,125.0	16,368.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	528.0	428.0
210803	Даатгалын үйлчилгээ	456.3	342.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	449.7	443.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	192.5	137.9
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**317,035.9**	**88,691.7**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	312,672.9	84,328.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,363.0	4,363.0
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**64,791.8**	**64,588.3**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**64,791.8**	**64,588.3**
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62,991.8	62,991.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800.0	1,596.5
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**1,278,467.4**	**883,163.8**
221001	Их засвар	345,000.0	251,442.4
222001	Тоног төхөөрөмж	147,443.3	38,999.5
223001	Бусад хөрөнгө	786,024.1	592,721.9
23	**ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР**	**159,072.0**	**125,518.0**
230001	Эргэж төлөгдөх зээл	159,072.0	125,518.0
III	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**3,305,648.1**	**2,710,389.8**
31	**ҮЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**639,696.8**	**623,682.7**
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	639,696.8	623,682.7
32	**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**1,997,529.7**	**1,979,470.5**
320001	Орон нутгийн төсвөөс	1,997,529.7	1,979,470.5
35	**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС**	**668,421.6**	**97,576.6**
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	159,072.0	97,576.6
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	509,349.6	-
36	**ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ**	**-**	**9,660.0**
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	-	9,660.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**108,324,555.00**	**272,491,601.00**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**108,324,555.00**	**272,491,601.00**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**95,797,817.00**	**260,033,179.33**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**		**44,213,019.80**
210101	Үндсэн цалин		7,133,466.34
210102	Нэмэгдэл		33,765,477.46
210104	Урамшуулал		3,314,076.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**		**3,977,786.83**
210201	Тэтгэврийн даатгал		2,744,853.59
210202	Тэтгэмжийн даатгал		318,223.01
210203	ҮОМШӨ-ний даатгал		254,578.41
210204	Ажилгүйдлийн даатгал		63,643.80
210205	Эрүүл мэндийн даатгал		596,488.02
2104	**Хангамж, бараа материалын зардал**	1,809,378.00	**563,000.00**
210402	Тээвэр, шатахуун	1,809,378.00	563,000.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**400,000.00**	**1,139,910.20**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400,000.00	1,139,910.20
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**93,588,439.00**	**210,139,462.50**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	**93,588,439.00**	210,139,462.50
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**12,526,738.00**	**12,458,421.67**
2133	**Олгосон санхүүжилт, шилжүүлэг**	**12,526,738.00**	**12,458,421.67**
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	**12,526,738.00**	6,355,503.50
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		6,102,918.17
I	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**95,797,817.00**	**272,491,601.00**
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**95,797,817.00**	**272,491,601.00**
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,769,602.00	263,430,376.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,028,215.00	9,061,225.00
III	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)**	**- 12,526,738.00**	**0**
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,526,738.00	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Батсүмбэр сум нь 2023 оныг Түүхт ой бүтээн байгуулалтыг дэмжих урианы жил болгон зарлаж, сумын 100 жилийн ой угтсан бүтээлч ажлын төлөвлөгөөг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 04 тоот тогтоолоор 4 бүлэг, 76 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр төлөвлөн 01 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар 47,2 хувийн хэрэгжилттэй байна.

Тайлант онд байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 9,900.0 мянган төгрөгөөр ногоон байгууламжийн хашаа, Сөгнөгөрийн постны барилгыг 8,000.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн ба ногоон байгууламжийг нэмэгдүүлж, 193548 ширхэг мод, бутыг үрээр болон мөчрийн тайрдас, тарьц суулгацаар тарьсан байна

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 47 зорилт 187 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 76,8 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Батсүмбэр сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтыг завсрын аудитаар хянаж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 134 тоотын дагуу сумын Засаг даргын удирдамжийн дагуу 5 хүний бүрэлдэхүүнтэй төсөвт байгууллагуудын шилэн дансанд хяналт хийхэд сумын хэмжээнд 10 байгууллага нийт дунджаар 97,9 хувьтай шалгагдсан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 4,905,183.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,016,181.8 мянган төгрөгөөр буюу 26,1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1325326.0	1512698.7	187372.8
АВЛАГА	253231.7	685944.8	432713.1
БАРАА МАТЕРИАЛ	190204.7	221613.4	31408.8
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2120718.8	2485406.0	364687.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3889481.2	4905663.0	1016181.8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3312.2	44790.8	41478.6
Засгийн газрын хувь оролцоо	3886169.0	4860872.1	974703.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3889481.2	4905663.0	1016181.8

Эх сурвалж: Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,512,698.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 187,372.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь өмнөх оноос орон нутгийн ерөнхий орлогын данс 185,473.0 мянган төгрөгөөр, эмийн эргэлтийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,899.7 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 685,944.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 432,713.1 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оноос Орон нутгийн хөгжлийн сангийн авлага 268,115.2 мянган төгрөгөөр, Засаг даргын тамгын газрын авлага 132,781.8 мянган төгрөгөөр хоршоо хөгжүүлэх сангийн авлага 30,247.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 221,613.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 31,408.8 мянган төгрөгөөр өссөн нь эмийн эргэлтийн сангийн авлага 18,846.9 мянган төгрөгөөр, Засаг даргын тамгын газрын 10,837.8 мянган төгрөгөөр өмнөх оноос нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,485,406.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 364,687.1 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын тамгын газар тайлант онд төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 221,603.4 мянган төгрөгийн, ОНХС-ийн болон бусад эх үүсвэрээс 344,938.0 мянган төгрөгийн нийт 566,541.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнаснаас шалтгаалсан байна.

Нийт өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 44,790.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 41,478.6 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн өглөг 40,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 4,860,872.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 974,703.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,512,698.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 187,372.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1325326.0	1512698.7	187372.8
Банкинд байгаа бэлэн мөнгө	1325326.0	1512698.7	187372.8
Төгрөг	1325326.0	1512698.7	187372.8
Төрийн сангийн харилцах	1300674.0	1486147.1	185473.0
Арилжааны банк дахь харилцах	24651.9	26551.7	1899.7

Эх сурвалж: Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 1,486,147.1 мянган төгрөгийн 74,0 хувь буюу 1,099,879.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 16,8 хувь буюу 249,563.6 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 9,2 хувь буюу 136,703.9 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл арилжааны банканд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 685,944.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 432,713.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	253231.7	685944.8	432713.1
Ажиллагчидтай холбогдсон авлага	200.5	200.5	0.0
Бусад авлага	253031.2	685744.3	432713.1
Байгууллагаас авах авлага	3962.9	407623.0	403660.1
Хувь хүмүүсээс авах авлага	249068.3	278121.3	29053.0

Эх сурвалж: Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын жилийн эцсийн үлдэгдэл 685,944.8 мянган төгрөгийн 40,2 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн, 39,3 хувийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 19,7 хувийг Засаг даргын тамгын газрын, 0,9 хувийг эмийн эргэлтийн сангийн авлага эзэлж байна.

<u>Аудитын илрүүлэлт</u>

- *Аймгийн хөрөнгө оруулалтын зардлаас Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн 100,000.0 мянган төгрөгөөс Монголиа Дижитал Скүүл ХХК-д 2023 оны 12 дугаар сарын 24-ны өдөр 60,000.0 мянган төгрөгийг шилжүүлж, барилга байгууламж дансанд орлогоор бүртгэсэн, үлдэгдэл 40.000.0 мянган төгрөгийг сумын ОНХС-д шилжүүлж зардлаар тайлагнасан алдааг аудитын явцад залруулж, авлагаар бүртгэсэн.*

ЗДТГ-ын авлагын эхний үлдэгдэл 2,000.0 мянган төгрөг нь 2021 онд булгийн эхийг хаших зориулалтаар олгож, ажлыг гүйцэтгээгүйгээс авлагаар бүртгэсэн 2022, 2023 онд уг ажил хийгдээгүй, авлага барагдаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 221,613.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 31,408.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
БАРАА МАТЕРИАЛ	190204.7	221613.4	31408.8
Түүхий эд материал	92597.9	111444.9	18846.9
Тусгай зориулалттай материал	14472.7	14472.7	0.0
Эм боох материал	78125.2	96972.2	18846.9
Хангамжийн материал	88606.8	105168.6	16561.8
Бичиг хэргийн материал	2902.8	2455.3	-447.5
Аж ахуйн материал	6679.3	6679.3	0.0
Сэлбэг хэрэгсэл	4865.0	5195.0	330.0
Түлш, шатах тослох материал	3086.1	4217.3	1131.2
Барилгын засварын материал	1157.6	4072.1	2914.5
Хүнсний материал	13228.0	12847.9	-380.1
Бусад хангамжийн материал	56688.0	69701.7	13013.8
Мал амьтад	0.0	5000.0	5000.0
НӨӨЦИЙН БАРАА	9000.0	0.0	-9000.0

Эх сурвалж: Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдэл 221,613.4 мянган төгрөгийн 44,5 хувийг эмийн эргэлтийн сангийн, 37,3 хувийг Засаг даргын тамгын газрын, 14,7 хувийг Ойн ангийн бараа материал эзэлж байна.

Бараа материалын оны эхний үлдэгдэл 31,408.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 316,231.0 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 284,822.1 мянган төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

- *ЗДТГ-ын бараа материал дансанд Ковидын үед бэлтгэсэн 14 нэр төрлийн 3,667.3 мянган төгрөгийн ариутгагч, нэг удаагийн маск, бээлий, халад, нүүрний хаалт зэрэг бараа, материалын чанар байдал, ашиглах хугацаа зэргийг шалгаж, муудах болон ашиглалтгүй болохоос урьдчилан сэргийлсэн арга хэмжээ авах зөвлөмж өгөгдсөн.*
- *ЗДТГ-ын ковш тракторын өвлийн техник үйлчилгээний тос масло, маслоны шүүр, гидрийн шингэн, урд хойд олгой, камерын зардалд 2,575.3 мянган төгрөгийг, Прадо-120 автомашины урсгал засварын зардалд 412.5 мянган төгрөгийг, Катын засварт 988.0 мянган төгрөг, катын олгойн үнэнд 700.0 мянган төгрөгийг техникийн комиссын дүгнэлт, нотлох бичиг баримтгүйгээр шилжүүлсэн зөрчилд зөвлөмж өгөгдсөн.*

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,485,406.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 364,687.1 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт үндсэн хөрөнгийн 93,2 хувийг Засаг даргын тамгын газрын хөрөнгө эзэлж байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	**2120718.8**	**2485406.0**	**364687.1**
Биет хөрөнгө	**1468322.8**	**1821394.6**	**353071.8**
Барилга, байгууламж, орон сууц	1141715.4	1272979.4	131264.0
Хуримтлагдсан элэгдэл	-264272.7	-399403.3	-135130.6
Авто-тээврийн хэрэгсэл	415943.5	508000.1	92056.7
Хуримтлагдсан элэгдэл	-241250.0	-297187.8	-55937.9
Машин тоног төхөөрөмж(компьютер)	239834.8	274083.3	34248.4
Хуримтлагдсан элэгдэл	-91916.0	-107503.9	-15587.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	84229.7	89807.2	5577.5
Хуримтлагдсан элэгдэл	-63414.5	-69105.5	-5691.0
Зам, гүүрийн байгууламж	1063506.3	1063506.3	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-1054545.5	-1056648.2	-2102.6
Бусад үндсэн хөрөнгө	378471.7	717836.7	339364.9
Хуримтлагдсан элэгдэл	-141023.3	-176013.1	-34989.9
Ном	1043.4	1043.4	0.0
Биет бус хөрөнгө	**652396.1**	**664011.4**	**11615.3**
Програм хангамж	3470.0	12220.0	8750.0
Хуримтлагдсан элэгдэл	-3021.9	-3808.6	-786.7
Бусад биет бус хөрөнгө	677256.0	680930.0	3674.0
Хуримтлагдсан элэгдэл	-25308.0	-25330.0	-22.0

Эх сурвалж: Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 364,687.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар төрийн албан хаагчдын орон сууцаар хангах хөтөлбөрийн санхүүжилт эрх шилжиж ирсэн 100,000.0 мянган төгрөгөөс Монголиа Дижитал Скүүл ХХК-д сумын Засаг даргын 2023 оны А/731 дугаар захирамжаар 2023 оны 12 дугаар сарын 24-ны өдөр 60,000.0 мянган төгрөгийг шилжүүлж, барилга байгууламж дансанд орлогоор бүртгэж тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Мөн зам гүүрийн барилга байгууламж дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн гэх Хүйн голын бетон гүүрийг 1,259,983.4 мянган төгрөгөөр хүлээн авсан акт, анхан шатны баримт материалгүйгээр бүртгэж тайлагнасныг залруулсан.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 44,790.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 41,478.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
НИЙТ ӨР ТӨЛБӨР	3312.2	44790.8	41478.6
Бусад өглөг	3312.2	44790.8	41478.6
Байгууллагад төлөх өглөг	3312.2	44790.8	41478.6

Эх сурвалж: Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 41,478.8 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн санд 40,000.0 мянган төгрөгийн өглөгийг шинээр бүртгэсэн мөн сумын Эрүүл мэндийн төвийн 972.1 мянган төгрөгийн цахилгааны өрийг нэгтгэсэнтэй холбоотой байна.

Нийт өр төлбөрийн 95,8 хувь нь орон нутгийн хөгжлийн сангийн, 1,9 хувийг эмийн эргэлтийн сангийн өглөг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын Эрүүл мэндийн төвийн цахилгааны өглөг 972.1 мянган төгрөгийг буруу нэгтгэснийг залруулах саналыг хүргэсэн боловч аудитын явцад залруулга хийгдээгүй болно.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,860,872.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,974,703.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Засгийн газрын хувь оролцоо	**3886169.0**	**4860872.1**	**974703.2**
Засгийн газрын оруулсан капитал /орон нутгийн	1112351.8	1112351.8	0.0
Хуримтлагдсан үр дүн	**2546909.7**	**3521612.9**	**974703.2**
Өмнөх үеийн үр дүн	7921559.8	2545777.7	-5375782.1
Тайлант үеийн үр дүн	-5374650.1	975835.2	6350485.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	226907.4	226907.4	0.0

Эх сурвалж: Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 974,703.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өсөлттэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Батсүмбэр сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,021,617.4 мянган төгрөг, нийт зарлагыг 4,140,415.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн мэдээллийг ирүүлсэн.

Батсүмбэр сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн “сумын 2023 оны төсөв батлах тухай“ 03 дугаар тогтоолоор 2023 оны төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 1,213,805.8 мянган төгрөгөөр, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 2,889,300.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Батсүмбэр сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн “Сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 199,481.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,413,287.1 мянган төгрөгөөр, 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг 416,347.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 3,305,648.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 17 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 1,413,287.1 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 584,242.5 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 507,643.3 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл 221,891.0 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс урсгал зардалд 10,379.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 227,079.6 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 159,072.0 мянган төгрөгийг тус тус бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 584,242.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 2,021,617.4 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд орлогын шилжүүлэг 623,682.7 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 261,370.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,631,995.9 мянган төгрөг буюу 79,6 хувьтай байгаа нь батлагдсан зардлын 248,297.9 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлж, 42,146.9 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн хэрэгжилтэд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс 228,041.1 мянган төгрөг дутуу зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өрөө удирдах ёсны байгууллага үндсэн үйл ажиллагааны зардал	118,264.0	118,057.7	206.3	99.8
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага үндсэн үйл ажиллагааны зардал	1,322,358.0	1,050,441.0	271,917.0	79.4
3	Ерөнхий боловсролын сургууль-тогтмол зардал	460,955.1	450,798.4	10,156.7	97.8
4	Сургуулийн өмнөх боловсрол -тогтмол зардал	55,427.2	54,525.0	902.2	98.4
5	Эрүүл мэндийн төв-тогтмол зардал	54,070.6	53,936.9	133.7	99.8
6	Ой анги-үндсэн үйл ажиллагааны зардал	103,796.8	102,240.5	1,556.3	98.5
7	Хоршоо хөгжүүлэх сан	159,072.0	125,518.0	33,554.0	78.9
8	ОНХС-н хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ	981,587.8	632,815.8	348,772.0	64.5
9	Баянгол цэцэрлэг	20,785.1	19,678.4	1,106.7	94.7
10	Соёлын төв	29,331.5	23,984.2	5,347.3	81.8
	Нийт	3,305,648.1	2,631,995.9	673,652.2	79.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар 260,708.1 мянган төгрөг, ИТХ 11,783.5 мянган төгрөг нийт 272,491.6 мянган төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 10 хөтөлбөрийн 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023-01.01-2023.12.31	Сумын ИТХТ, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангаж ажилласан	118,264.0	118,057.7
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хэрэгжүүлэх	Хэрэгжилт 79,44%	1,322,358.0	1,050,441.0
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01-2023.12.31	Хоршоо хөгжүүлэх сангийн журмыг дагаж мөрдөх	Шаардлага хангасан зээл ирээгүй тул олголт багассан 26,7%	159,072.0	125,518.0
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Хэрэгжилт 97,8%	460,955.1	450,798.4
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Хэрэгжилт 98,37%	76,212.3	74,203.4
6	71702-Соёлын үйлчилгээ	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Хэрэгжилт 91,0%	29,331.5	23,984.2
7	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Хэрэгжилт 99,75%	54,070.6	53,936.9
8	71403-Ойн анги	2023.01.01-2023.12.31	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг бүрэн	Хэрэгжилт 98,5%	103,796.8	102,240.5
9	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх	Хэрэгжилт 64,47%	981,587.8	632,815.8

3.5.4 Худалдан авах ажиллагаа

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг дарга нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэн тайлагнасан байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу Үдлэг багийн спортын залуучуудын талбай, Баянгол багийн залуучуудын талбай, Цогт-Өндөр багийн тоглоомын талбай, наадмын талбай шинэчлэх, нийтийн эзэмшлийн гудамж талбай шинэчлэх, Сөгнөгөр-Баянгол 3-р багийн сургууль, цэцэрлэгийн их засвар, 1,3,4 дүгээр багийн худгийн цахимжуулалт гэсэн арга хэмжээнүүдийн тендер зарлагдаж, шалгарсан компаниуд ажлыг гүйцэтгэсэн, шууд худалдан авалтаар 11 ажил гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт шинжээч Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2024 оны 3 дугаар сарын 05-ний өдрийн 05/70 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийн орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийг, суурь үзүүлэлтийг орон нутгийн төсвийн орлого 1,413,287.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 21,199.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 15,899.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг байршуулсан боловч зарим алдаа зөрчлийн талаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж мэдээллийг үнэн зөв бүрэн мэдээлж ажиллахыг зөвлөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай зохих ёсоор нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн, хэрэгжилтийг фас системд оруулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	15,089.5	3	15,089.5	100
Нийт дүн	3	15,089.5	3	15,089.5	**100**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 972.1 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 972.1 мянган төгрөгийн алдааг залруулаагүй болно.

1. Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан, бодит байдлын мэдэгдэл, тайлбар тодруулга, аудитад шаардлагатай баримт материалыг хугацаандаа ирүүлээгүй, санхүүгийн нэгтгэсэн тайланд Эрүүл мэндийн төвийн 972.1 мянган төгрөгийн цахилгааны өрийг буруу нэгтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д ”үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “ангилал”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

> Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдээгүй ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад залруулга хийхийг зөвлөв.

Аудитаар орлогын төлөвлөлт бүрдүүлэлттэй холбоотой зөрчил илэрсэнд 2 зөвлөмж хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 103.6 хувиар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөр авч үзэхэд 8 нэр төрлийн орлого 7,1-77,1 хувиар тасарсан байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтэд ойн төлбөрийг орлого тасарсан нь гол нөлөө үзүүлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд биелүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

2. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аудитад хог хаягдлын хураамж, малын тоо толгойн албан татварын ногдуулалт, төлөлтийн судалгаа тайлан байхгүй гэж холбогдох мэдээлэл ирүүлээгүй ба сумын хүн ам, малын тоо толгойд харьцуулсан судалгаа хийхэд татварын орлогын дүн зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг

хангасан байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Малын тоо толгойн албан татварыг ОНХС-д бүрэн төвлөрүүлэх ба татварын орлогыг ногдуулалт мэдээлэлд үндэслэн бодитой төлөвлөж байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу Төв аймаг дахь Төрийн аудитын газарт батлагдсан төлөвлөгөөг 2024 оны 4 дүгээр сарын 25-ны дотор, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	972.1			1	972.1			1	972.1	1	
ЗДТГ	3	1,360,533.6	1	100,000.0	2	1,260,533.6	3	1,360,533.6				
ОНХС	1	373,533.7			1	373,533.7	1	373,533.7				
Дүн	5	1,735,039.4	1	100,000.0	4	1,635,039.4	4	1,734,067.3	1	972.1	1	972.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг дарга	1	0					1	0				
ЗДТГ	1	2,000.0	1	2,000.0								
Дүн	2	2,000.0	1	2,000.0			1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ОНХС	1	672,015.4					1	672,015.4
Дүн	1	672,015.4					1	672,015.4
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Засаг дарга	1	0					1	0
ЗДТГ	3	19,285.4	1	10,872.2			2	8,413.2
ИТХ	2	5,691.9	1	2,525.3			1	3,166.6
Дүн	6	25,977.3	2	13,397.5			4	12936.9
Нийт дүн	7	696,992.7	2	13,397.5			5	683,595.2